

2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	7 хоногийн ажлын товч мэдээлэл
1	<p><b>ХӨЛ ХОРИОНЫ ДЭГЛЭМ САХИУЛЖ БАЙНА</b> Баян-Өлгий аймгийн Засаг даргын А/148 дугаар захирамжийн дагуу Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын алба хаагчид Өлгий сумын 9 чиглэлд хөл хорионы дэглэм сахиулж байна. Өнгөрсөн хоногт Өлгий-Ховд чиглэлийн хөдөлгөөний хязгаарлалтын дэглэмийг зөрчсөн иргэдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэлийн арга хэмжээ авч, зөрчил гаргасан иргэдийг Өлгий сумын чиглэлд буцаалаа.</p>
2	<p><b>ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ ХАНГУУЛАХЫГ УРИАЛЖ БАЙНА</b> COVID-2019 халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Мэргэжлийн хяналтын газраас хүргүүлсэн мэдэгдэл, зөвлөмжийн дагуу Цагааннуур хүүхдийн цэцэрлэг, Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг, Өлгий сумын 6, 8, 10 дугаар цэцэрлэгүүд хүүхдийн тоглоомуудыг угааж, гадна, дотор, бүх өрөө тасалгаануудын хог хаягдлыг цэвэрлэж, ариутгал халдваргүйтгэл хийлгүүлэв. Бусад сургууль, цэцэрлэгүүдийг эрүүл ахуйн нөхцөлийг хангуулж, ариутгал, халдваргүйтгэл хийж ажиллахыг УРИАЛЖ байна.</p>
3	<p><b>ЗАХИРАМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАВ.</b> Аймгийн Засаг даргын А/128 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд ресторан, кафе, зоогийн газруудын иргэдэд үйлчлэх цагийн хязгаарыг оройн 20:00 цаг хүртэл, баар, караоке, шашин /сүм, хийд, мөргөлийн газрууд, биллиард, саун, фитнесс, бүжиг, иогийн кулб/ болон олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр хугацаагаар хориглосонтой холбогдуулан оройн цагаар аймгийн төвийн үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа.</p>
4	<p>Тандалт судалгаа хийв Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ,сэжигтэй тохиолдлыг илрүүлэх хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн нислэгээр зорчих зорчигчдын эрүүл мэндэд Шипагер ӨЭМТөвийн эмч мэргэжилтнүүдтэй хамтарч Өлгий-Улаанбаатарын чиглэлд 58, Улаанбаатар-Өлгийн чиглэлд 74, нийт 135 зорчигчийн эрүүл мэндийн байдалд тандалт судалдаа хийж ажиллав. Хяналт,тандалтаар өвчний шинж тэмдэгтэй сэжигтэй тохиолдол илрээгүй</p>